

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, төлөвлөгөө, сурах бичгийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цэдэвдорж Чимэдлхам

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Хос хэлний талаар баримтлах чиглэл батлуулна.							
1	Хос хэлний талаар баримтлах чиглэл батлуулна.	Хос хэлний талаар баримтлах чиглэл	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн хийсэн судалгаа, судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулсан хос хэлний сургалтын чиглэл, арга зүй	Хос хэлний талаар баримтлах чиглэл Боловсролын сайдын тушаалаар батлагдсан байна.	1.Хос хэлний сургалтыг тодорхойлж, "Үзэл баримтлал батлах тухай" Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-д тусган батлууллаа. Тус үзэл баримтлалын "3.Сургалтын хөтөлбөр, түүний бүтэц,боловсруулахад тавих шаардлага" хэсэгт "Өөр хэл бүхий үндэстний цөөнхийн болон олон соёлт гэр бүлтэй суралцагчийн сургалтыг	10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					агуулга болон хэлийг интеграцчилан заах арга зүй (АХИС)-г баримталж зохион байгуулна" хэмээн тусгаж батлуулав. Мөн хос хэлний боловсрол гэж хоёр буюу түүнээс дээш хэлээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн боловсролын нэг төрөл гэж тодорхойлж өгсөн. 2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 7.3-д "Энэ хуулийн 7.2-т заасан суралцагч Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу хос хэлний хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэсэн зохицуулалт шинээр нэмэгдсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-д үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний төсөл боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Төлөвлөгөө, зардал	
--	--	--	--	--	--	--

					батлах тухай" 2024 оны А/317 дугаар тушаалаар батлуулав. Тус төлөвлөгөөний дагуу бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулав. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын боловсруулсан казах, тува хэлний сургалтын хөтөлбөртэй танилцах зорилготой уулзалтыг БНБТГ, ЕБГ, ЦБГ, СӨБХ-ийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулж, сайжруулан Баян-Өлгий аймгийн 3 ерөнхий боловсролын сургуульд туршиж байна. 3.Хос хэлний талаар баримтлах чиглэлийн төслийг боловсруулж, Баян-Өлгий аймгийн 6 сургуульд туршин үр дүнг тооцсон. Чиглэлийг Боловсролын сайдын тушаалаар батлахыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс түр хүлээлгэсэн болно. Хавсралт: 5 файл		
--	--	--	--	--	---	--	--

1.2. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ.

2	Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ.	Үзэл баримтлал баталсан Засгийн газрын тогтоол	Судалгаа, хэлэлцүүлэг	-	Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Боловсролын ерөнхий хуулийн 23.1, 23.4-д заасан Боловсролын үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаанаар 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр хэлэлцүүллээ. Хуралдаанд Боловсролын үндэсний зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Боловсролын үндэсний зөвлөлийн дэд дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд нар оролцож, 72.3 хувийн ирцтэй хуралдав. Боловсролын үндэсний зөвлөлийн хуралдаанаар уг үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх шийдвэр гаргав. Тус үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр холбогдох баримт бичгийн хамт Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 1а/1642 дугаар албан бичгээр хүргүүлэв. Үзэл баримтлалын төслийг Засгийн газрын 2024 оны	1-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	---	--	-----------------------	---	---	------------------	--

					04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээ. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг "Үзэл баримтлал батлах тухай" Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор баталсан. Хавсралт: 1 файл		
1.3. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөөний төсөл боловсруулна.							
3	Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөөний төсөл боловсруулна.	Сургалтын хөтөлбөр шинэчлэх батлагдсан төлөвлөгөө	Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн батлагдсан үзэл баримтлал	Сургалтын хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөөг БШУ-ы сайдын тушаалаар батлуулах	БСҮХ-ийн захирал М.Итгэл, эрхлэгч Х.Отгонбаатар, БҮТ-ийн захирал Л.Ганбат, БЕГ-ын Газрын дарга Б.Лхагвабаяр тэргүүтэй албан хаагчдыг оролцуулан 2024 оны 2-р сарын 19,21,23-ны өдөр БШУЯ-ны 111-р өрөөнд уулзалтууд хийж сургалтын хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах зарчмыг тохиролцлоо. "Үзэл баримтлал батлах тухай" Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					үзэл баримтлал"-д үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний төсөл боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Төлөвлөгөө, зардал батлах тухай" 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/317 дугаар тушаалаар батлууллаа. Баталсан тушаалын дагуу сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д үндэслэн холбогдох мэргэжлийн байгууллага, сургалтын байгууллага, судлаач, эрдэмтэн, багш нартай хамтран шинэчлэх, тохирцыг шалгах үйл ажиллагааг 2024-2029 онд хэрэгжүүлэх юм. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бага ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, тохирцыг шалгах ажлыг 2024-2025 оны хичээлийн жилд эхлүүллээ. Шинэчилсэн сургалтын	
--	--	--	--	--	--	--

					төлөвлөгөө, хөтөлбөрт нийцүүлэн суралцагчийн дасгал ажлын дэвтэр, багшийн ном, цахим сургалтын сан, гарын авлага боловсруулах, тэдгээрийн тохирцыг шалгаж, сайжруулах ажлыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хариуцан гүйцэтгэж байна. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв хамтран шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн дагуу үнэлгээний шалгуур, зөвлөмж боловсруулах, даалгаврын сан шинэчлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдлагад зориулсан сургалт зохион байгуулах, шинэчилсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэл хангах ажлыг хийж гүйцэтгэж байна. Хавсралт: 2 файл		
1.4. ыбө							
4	Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт	Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор	Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулгыг багтаасан	Ерөнхий боловсролын сургуулиудад авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх арга хэмжээг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусгах тодорхой арга хэмжээ авсан байна.	багтаасан ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр	батлагдсан Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр	ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн төслийг ерөнхий боловсролын сонгосон сургуульд туршина.	хичээлийн бус цагаар хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах талаар АТГ- ын албан хаагчид, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн удирдлагуудтай хэлэлцэн тохирох зорилготой уулзалтууд зохион байгуулсны үр дүнд БСҮХ нь Авилгатай тэмцэх газартай хамтран "Ёс суртахууны хариуцлага" хэмээх сургалтыг дэмжих туршилтын сургалтын хөтөлбөр боловсруулж, 2023-2024 оны хичээлийн жилийн 3-4 дүгээр улиралд нийслэлийн 8, аймаг, сумын 8 нийт 16 сургуулийн 10 дугаар ангийн 480 орчим суралцагчийг тус хөтөлбөрийн дагуух сургалтад хамрууллаа. Сургалтын хөтөлбөрийн туршилтын үр дүнг БСҮХ- тэй хамтран нэгтгэн дүгнэлээ. АТГ-ын холбогдох удирдлага, мэргэжилтнүүдтэй сургалтын хөтөлбөрийн туршилтын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар 3 удаа уулзалт зохион байгуулж, санал солилцон туршилтын сургалтын хөтөлбөрийг "Ёс суртахууны хариуцлага"	сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	---	--	--	--	--	---

					сургалтын хөтөлбөр болгон эцэслэн боловсрууллаа. Тус сургалтын хөтөлбөрийг Боловсролын сайдын "Сургалтыг дэмжих хөтөлбөр батлах тухай" 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаалаар батлуулан ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид хэрэгжүүлж эхэлсэн. Хавсралт: 2 файл		
1.5. Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусгах арга хэмжээ авч, тусгана.							
5	Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусгасан байна.	Бага боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрийн төсөлд авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэхээр тусгасан агуулга, сэдэв	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр	Бага боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрийн төсөлд авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдэв тусгасан байна.	Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-д үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний төсөл боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Төлөвлөгөө, зардал батлах тухай" 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/317 дугаар тушаалаар батлууллаа.	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бага ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, тохирцыг шалгах ажлыг 2024 оноос эхэллээ. Бага ангийн шинэчилэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн төсөлд авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулгыг тусгасан. Шинэчилсэн сургалтын хөтөлбөр, тэдгээрийн туршилт эхлүүлэх ажлын явцтай танилцах зорилготой уулзалтыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн албан хаагчид, БНБТГ, ЕБГ, ЦБГ, СӨБХ-ийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулж, тодорхой чиглэл, зөвлөмж өглөө. Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн туршилтын ажлын явцтай нийслэлийн 24-р сургууль дээр ажиллаж танилцлаа. Туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж буй 1-3-р ангийн суралцагчид, тэдний эцэг эх, хичээл заасан багш нартай ярилцаж, санал бодлыг нь сонслоо. Багш нарын зүгээс туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж буй	
--	--	--	--	--	---	--

					ажлын нэмэгдэл хөлс олгох санал тавьсан. Хавсралт: 3 файл		
1.6. Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журмын төсөл боловсруулна.							
6	Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журмын төсөл боловсруулна.	Журмын төсөл боловсруулж, батлуулсан байна.	Боловсролын ерөнхий хууль	-	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.7-д "Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасны дагуу "Ерөнхий боловсролын сургуульд төрөлжсөн сургалт зохион байгуулах журам"-ын төсөл боловсрууллаа. Журмын төсөл нь ерөнхий боловсролын сургуулийн "Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт"-ыг зохицуулж байсан журмыг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нийцүүлэн зөвхөн "Төрөлжсөн" сургалт болгон шинэчилсэн онцлогтой. Тухайн чиглэлийн төрөлжсөн сургалтад хамрагдах нэг суралцагчид ногдох зардлыг Засгийн газрын "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам	3-р сар, 4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					батлах тухай” 2024 оны 39 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн”-ий “Нийт хувьсах зардал”-ын 30 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээтэй байхаар журамд тусгасан. Сургалтын нэмэлт зардал нь зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд хамаарахаар журамлав. Журмын төсөлд яамны холбогдох газар, хэлтэс, Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиудаас тус тус санал авч судлан тусгалаа. Журмын төслийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Журам батлах тухай” 2024 оны А/262 дугаар тушаалаар батлууллаа. Журмын холбогдох материалыг бүрдүүлэн журмын хамт	
--	--	--	--	--	--	--

					Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлээ. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 6-р сарын 05-ны өдрийн 1/2884 албан бичгээр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6844 дугаарт бүртгэсэн. Ерөнхий боловсролын сургуульд төрөлжсөн сургалт зохион байгуулах журам ерөнхий боловсролын нийт сургуульд амжилттай хэрэгжиж байна. Хавсралт: 1 файл		
1.7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнана.							
7	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнана.	Хугацаанд нь тайлагнасан байна.	2023 оны биелэлтийн хувь	Хэрэгжилт хангагдсан, хугацаанд нь тайлагнасан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтийг нь тухай бүр хугацаанд нь тайлагнаж ажиллалаа. Тайлангийн энэ хэсэгт удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын талаар нэмж оруулав. •БШУ-ы Сайдын "Чадамжийн хүрээ батлах тухай" 2024 оны А/57	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дугаар тушаалаар "Албан болон албан бус боловсролын сургалтаар иргэдийн эзэмшвэл зохих мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн хүрээ"-г батлуулж, БСҮХ нь чадамжийн хүрээнд тулгуурлан Насан туршийн суралцахуйн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн сургалтын хөтөлбөр боловсрууллаа. •БШУ-ы Сайдын "Үндэсний чуулган зохион байгуулах, зардал батлах тухай" 2024 оны А/58 дугаар тушаалаар "Монголын боловсролын хувирган өөрчлөлт" үндэсний чуулганыг 2024 оны нэгдүгээр улиралд багтаан зохион байгууллаа. •Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2024 оны А108/А255 дугаар тушаалаар "Ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол болон дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч, залуучууд, насанд хүрэгчдийн мэргэжил сонгох,	
--	--	--	--	--	---	--

					суралцах, хөгжих боломж нэмэгдүүлэх ажлын хэсэг, удирдамж батлуулав. •Бурханы шашны сургалтын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 48 дугаар тогтоол, 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдааны 34 дүгээр тэмдэглэлийг хэрэгжүүлэхээр НЕБ-ын 112 дугаар сургуулийн бага, дунд, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөний төсөл боловсруулж, “Сургалтын төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэхтэй холбогдох зарим арга хэмжээ авах тухай” Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар батлууллаа. •НЕБ-ын 112 дугаар сургуулийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар холбогдох баримт бичгийн хамт хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 40 дүгээр тэмдэглэл гарлаа. Хавсралт: 6 файл		
--	--	--	--	--	--	--	--

1.8. Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана							
8	Салбарын болон яамны мэдээллээр иргэд, албан тушаалтанд үйлчлэх	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллээр иргэдэд албан тушаалтанд ил тод үйлчлэх	Холбогдох хууль тогтоомж, баримт бичиг	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллээр иргэдэд үйлчлэх, тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх, албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг журамд заасан хугацаанд хариу өгөх, баримт бичгийг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь бүрэн бүрдэлтэйгээр архивд хүлээлгэн өгөх	Албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг журамд заасан хугацаанд бэлтгэж, Боловсролын сайдын 26, Төрийн нарийн бичгийн даргын 20, газрын даргын 16 албан бичгээр хариу хүргүүлсэн. Мөн 11-11 мэдээллийн төв болон албаны утсаар ирсэн өргөдөл гомдол, хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч, иргэдтэй биечлэн уулзаж зохих мэдээллээр үйлчиллээ. Хариуцсан ажлын чиг үүргийн дагуух 2023 оны албан баримт бичгийг архивын нэг нэгж болгон бүрдүүлж хүлээлгэн өглөө.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль, Боловсролын хууль, бусад хууль тогтоомжийг судлах	Шинээр батлагдсан хууль, тогтоомжийг судлах	2023 оны түвшин	Шинээр батлагдсан хууль, тогтоомжийг судлах	Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сард баталсан Боловсролын ерөнхий хууль болон түүнийг дагалдан гарсан хуулиудыг уншиж судаллаа. Боловсролын сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажилласан талаар тайлангийн энэхүү хэсэгт нэмж оруулав. •БШУС-ын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2024 оны А/121 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон төрийн бус өмчийн олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургуулийн холбогдох баримт бичигт шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-т сургуулиудаас холбогдох баримт бичиг цуглуулж, дүгнэлт гаргаж ажиллалаа. •БШУС-ын "Дэд ажлын хэсэг байгуулж, зардал батлах тухай" 2024 оны А/215-р тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж, Монгол багш нарын 8-р их хуралд Ерөнхий боловсролын салбар хуралдааныг хариуцаж ажиллалаа. Тус албар хуралдаанаар ерөнхий боловсролын түвшинд VII их хурлаас VIII их хурал хүртэлх хугацаанд багшийн талаар хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ болон	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					ирээдүйн суралцагчийн дүр төрхийн талаарх илтгэл хэлэлцүүлэв. Багш нарын 7-р их хурлаас гаргасан тогтоолын хэрэгжилтийн тайлан гаргаж, Монголын багш нарын 8-р их хурлаас гаргах зөвлөмжийн төсөл боловсруулав. “Монголын багш нарын 8-р их хурал”-ын мэдээллийг нэгтгэн /мэргэжлийн боловсрол-28, дээд боловсрол-28, ерөнхий боловсрол: нийт 496 санал, нийт 251 нүүр санал/ эмхэтгэв. ТНБД-ын “Гэрээ байгуулах эрх олгох тухай” 2024 оны А/156 дугаар тушаал батлуулж эмхэтгэл хэвлүүлэв. •БШУС-ын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2024 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан "БШУЯ-ны харьяа байгууллагын төсвийн шууд захирагч нарын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт үнэлэх ажлын хэсэгт ажиллалаа. •Боловсролын сайдын "Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай" 2024 оны А/194 дүгээр тушаалаар батлагдсан "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсэгт ажиллав.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, төлөвлөгөө, сурах бичгийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цэдэвдорж Чимэдлхам

/...../

Огноо: